



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 06 өдөр

Дугаар A/597

Нарийнтээл сум

Мал амьтны гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчнөөс  
урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын  
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Захиргааны өрөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 02-ны A/597 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд мал, амьтны гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаажуулалтын ажлыг 2024 оны 08 дугаар сарын 09-нөөс 2024 оны 08 дугаар сарын 30-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Багийн малчид, иргэдэд дархлаажуулалтын ажлын зар, мэдээллийг цаг тухайд нь хүргэж, хариуцсан багийн мал сүргийг тогтоосон хугацаанд бүрэн хамруулахыг багийн Засаг дарга наарт даалгасугай.

3. Хонь, ямааны цэцэг өвчний вакцинуулалтын арга хэмжээг хийж гүйцэтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

4. Хонь, ямааны цэцэг өвчний вакцинуулалтанд зарцуулах хөрөнгийн зардлыг малын тоо толгойн албан татварын хөрөнгөөс зарцуулахыг төсвийн өрөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д зөвшөөрсүгэй.

5. Хонин сүрэгт хийх мал, амьтны гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчний дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, ажлын явц, үр дүнд хяналт тавьж, дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Бямбадолгор)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.СУГАР



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
НАРИЙНТЭЭЛ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 11 өдөр

Дугаар A/158

Нарийнтээл сум

Ажил хүлээлцэх, хяналт тавих  
ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа "Залуучуудын фитнесс төв байгуулах тоног төхөөрөмж нийлүүлэх" ажилд хяналт тавьж, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхамсүрэн (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)  
Гишүүд: Ц.Цэвээнсүрэн (Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны  
мэргэжилтэн)

Г.Гантоотох (МХЦХЦ-ийн малын эмч)  
П.Самдан (Олон нийтийн цагдаа)  
Д.Данаасүрэн (Иргэний төлөөлөл)

2. Залуучуудын фитнесс төв байгуулах тоног төхөөрөмж нийлүүлэх ажилд хяналт тавьж, хүлээн авч, орон нутгийн өмчид бүртгэн, архивын нэгж бүрдүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Лхамсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.СҮГЭР





ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
НАРИЙНТЭЭЛ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 19 өдөр

Дугаар A/139

Нарийнтээл сум

Мал, амьтны гоц халдварт бол малын мянган өвчнөөс  
урьдчилан сэргийлэх яаралтай вакцинуулалтийг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт бол малын мянган өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинуулалтыг 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдрөөс зохион байгуулахыг "Бумбат суврага" мал эмнэлэг үйлчилгээний нэгжид (Д.Цэцгээ)-д үүрэг болгосугай.

2. Мал, амьтны гоц халдварт Бог малын мянган өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, зардлын тооцоог хавсралтаар байгуулсугай.

3. Бог малын мянган өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины дархлаа тогтох хүртэлх хугацаанд малчдын нүүдэл, малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байх, дархлаажуулалтын товыг мал бүхий иргэд, малчин нарт зарлан мэдээлж ажиллахыг багийн Засаг нардаа үүрэг болгосугай.

4. Мал, амьтны гоц халдварт "Бог малын мянган" өвчиний дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үр дунд хяналт тавьж, холбогдох газарт тайлagnаж ажиллахыг мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Бямбадолгор)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.СУГАР



Нарийнтээл сумын Засаг даргын 2024  
оны 08 дугаар сарын 19. ны өдрийн А/139  
дугаар захирамжийн хавсралт



БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Д.Бямбадолгор (Мал эмнэлгийн тасгийн дарга)  
Гишүүдэд: П.Төмөртогоо (Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)  
Д.Цэцгээ (Малын их эмч)  
О.Цэрэннадмид 1 дүгээр багийн Засаг дарга  
Б.Базарсад (2 дугаар багийн Засаг дарга)  
Б.Ган-Өлзий (Баянтээг багийн Нийгмийн ажилтан)  
Д.Сугарсүрэн (Мал эмнэлэг хорио цээрийн хяналтын цэгийн  
малын эмч)  
О.Энх-Амгалан (ИТХ-ын жолооч)  
А.Батмөнх (жолооч)

\_\_\_\_\_ ооо \_\_\_\_\_



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А1140

Нарийнтээл сум

Г Үнэлгээний хороо байгуулах тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1, 45 дугаар зүйлийн 45.5, 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өндөрхөмөг багийн төвийг засварлах, өргөтгөх ажлын тендерийн гүйцэтгэгчийг сонгох үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Отгонтuya (Татварын Улсын байцаагч)

Гишүүд: Ц.Сайнбилэг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Ц.Сувд-Эрдэнэ (Нягтлан бодогч)

Д.Данаасүрэн (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Ч.Оюунзул (Архив, бичиг хэргийн ажилтан)

2.Өндөрхөмөг багийн төвийг засварлах, өргөтгөх ажлыг гүйцэтгэх тендерийн техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичиг боловсруулах, тендер хүлээн авах, нээх, хаах, тендерийг хянан үзэх, үнэлгээний дүгнэлт гаргах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Д.Отгонтuya)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.СУГАР





ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 20 өдөр

Дугаар АИЧI

Нарийнтээл сум

Г Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 19 дүгээр зүйлийн 19.1, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 1 дүгээр багийн “Сөртийн ам” гэх газарт зусаж байгаа малчин Ц.Одгэрэл, С.Чимэдбат, “Халуун түрүү” гэх газарт зусаж байгаа малчин Л.Ганбат, Р.Сугар, А.Батсүрэн, Ш.Гомбосүрэн нарын малд малын гоц халдварт болгын малзан өвчин илэрсэн тул “Сөрт”, “Халуун түрүү”, Баянтээг багийн “Хүйтэн” гэх нутаг дэвсгэрийг 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2.Хорио цээрийн дэглэмийн үед ажиллах мэргэжлийн баг болон төсвийн зардлыг хавсралтаар тус тус баталсугай.

3.Хорио цээрийн бүсэд хийгдэх халдвартгүйтгэл, дархлаажуулалтыг чанартай зохион байгуулахыг Мал эмнэлэгийн үйлчилгээний нэгжийн эмч (Д.Цэцгээ)-д үүрэг болгосугай.

4.Малын гоц халдварт бол малын малзан өвчин тархахаас хамгаалж хорио цээрийн дэглэм сахиулах, голомтын бүсэд ажиллах, техник хэрэгсэл, хүн хүчийг дайчлан гаргаж, холбогдох хууль, журмыг мөрдүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Б.Ичинноров), арга хэмжээнд шаардагдах зардлыг тооцож ажиллахыг Төсвийн ерөнхий няглан бодогч (Г.Наранхүү)-д тус тус даалгасугай.

5.Голомтын бүсэд малын шилжилт хөдөлгөөн, нүүдэл хийх, голомтын бүсээс мал малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн гаргахыг түр хугацаагаар зогсоож, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Бямбадолгор), цагдаагийн хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч (У.Мягмарнасан) нарт үүрэг болгосугай.

6. Малчид, иргэд, олон нийтэд хонь, ямааны цэцэг өвчний талаарх мэдээллийг хүргэж урьдчилан сэргийлэх зөвлөмж, гарын авлага, цахим мэдээллээр хангаж, хамтран ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Б.Ичинноров), Мал эмнэлгийн тасгийн дарга (Д.Бямбадолгор) нарт тус тус үүрэг болгосугай.





ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/149

Нарийнтээл сум

Г Тусламж үзүүлэх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын иргэн Д.Довчин, С.Адъяадолгор нар өвчний улмаас нас барсан тул ар гэрт нь 200,000 (хоёр зуун мянган) төгрөгийн тусламж үзүүлсүгэй.

2. Дээрх 200,000 төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/143

Нарийнтээл сум

Г Тусламж үзүүлэх тухай Г

Монгол Улсын Засаг захирагаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын иргэн П.Пунцагцэрэн, Ц.Баатар нар өвчний улмаас нас барсан тул ар гэрт нь 300,000 (гурван зуун мянган) төгрөгийн тусламж үзүүлсүгэй.

2. Дээрх 300,000 төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР